



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 19 өдөр


Дугаар Я/486

Улаанбаатар хот

Г Томуу, томуу төст өвчний бэлэн байдал,
хариу арга хэмжээний удирдамж
батлах тухай

Монгол Улсын Засгийн Газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөрийн 3 дугаар зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Томуу, томуу төст өвчний бэлэн байдал, хариу арга хэмжээний удирдамжийг нэгдүгээр, томуу, томуу төст өвчин, амьсгалын замын цочмог халдвартыг мэдээлэх маягтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Томуу, томуу төст өвчний бэлэн байдал, хариу арга хэмжээний удирдлагаар хангаж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/, тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн дарга захирал, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга наарт үүрэг болгосугай.
3. Томуугийн улиралд хэрэгжүүлэх хариу арга хэмжээ болон Дархан-Уул, Дорнод, Орхон, Ховд аймаг, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн вирус судлалын салбар лабораториудын урвалж, оношлуурт шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгахыг эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал наарт үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Я.Амаржаргал/-д даалгасугай.
5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2014 оны 358 тоот тушаалын 3 дугаар хавсралт, 2017 оны А/346 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



141201939

Эрүүл мэндийн сайдын 2020 оны
10 сарын 19 өдрийн тушаалын
нэгдүгээр хавсралт 482

ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ БЭЛЭН БАЙДАЛ,
ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ

Нэг. Үндэслэл

Дэлхий дахиньг хамарсан 1918 оны томуугийн цар тахлаас хойш 100 жил өнгөрсөн байна. Энэ хугацаанд цартахлын 3 удаагийн дэгдэлт гарч 55 сая гаруй хүн амь насаа алджээ. Тухайлбал 2009 онд томуугийн A хүрээний H1N1 шинэ вирусийн халдварт гарч, дэлхий дахинд 200 сая хүн, манай улсад 50 мянга гаруй хүн өвчилсөн байдаг.

Томуу, томуу төст өвчин нь богино хугацаанд олон хүнийг хамран өвчлүүлж, хүндрэл, эндэгдэлд хүргэдгээрээ нийгмийн эрүүл мэндийн анхаарал татсан асуудал хэвээр байна. Тухайлбал дэлхийд жил бүр 3-5 сая хүн томуугийн улмаас хүндэрч, 290,000 - 650,000 хүн нас барж байгаа талаар мэдээлж байна.

Хоёр. Зорилго

Томуу, томуу төст өвчний тархалтын үе шатыг ДЭМБ-ын зөвлөмж болгосон аргачлалын дагуу үнэлж, тархалтын үе шат бүрт тохирсон эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулахад оршино.

Гурав. Зорилт

3.1 Томуу, томуу төст өвчний тархалтын үе шат бүрт тохирсон эрүүл мэндийн тусламж үйлчилгээний халдвартын сэргийлэлт, хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэх

3.2 Томуу, томуу төст өвчний тархалтын үе шат бүрт бэлэн байдал, хариу арга хэмжээг зохион байгуулах

Дөрөв. Тохиолдлын тодорхойлолт

4.1 Томуу, томуу төст өвчин - сүүлийн 10 хоногт 38°C дээш халуурах, ханиалгах шинжээр илрэх амьсгалын замын цочмог халдварт (Өвчний олон улсын ангилал-10: код J00-J22);

4.2 Амьсгалын замын цочмог хүнд халдварт - сүүлийн 10 хоногт 38°C дээш халуурах, ханиалгах шинжээр илрэх эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх шаардлагатай амьсгалын замын цочмог халдварт (Өвчний олон улсын ангилал-10 код-J00-J22);

4.3 Нэг хамт олон, байгууллага, гэр бүл, хэсэг бүлэг хүн амын дунд 2 ба түүнээс дээш хүнд 10 хоногийн хугацаанд ижил эмнэлзүйн шинж тэмдэг илрэхийг “голомтолсон өвчлөл” гэж тус тус үзнэ.

4.4 Томуугийн цартахал болон улирлын томуугийн хүндрэлийн үнэлгээгээр томуугийн улирлын босго үзүүлэлтээс томуу, томуу төст өвчний 10,000 хүн ам дах үзүүлэлт 2 долоо хоног дараалан давсан тохиолдол нь идэвхжлийн үе;

4.5 Томуугийн цартахал болон улирлын томуугийн хүндрэлийн үнэлгээгээр алаг цоог дэгдэлтийн босго үзүүлэлтээс томуу, томуу төст өвчний 10,000 хүн ам дах үзүүлэлт 2 долоо хоног дараалан давсан тохиолдол нь алаг цоог дэгдэлтийн үе;

4.6 Томуугийн цартахал болон улирлын томуугийн хүндрэлийн үнэлгээгээр улсын хэмжээний дэгдэлтийн босго үзүүлэлтээс томуу, томуу төст өвчний 10,000 хүн ам дах үзүүлэлт 1 долоо хоног давсан тохиолдол нь улсын хэмжээний дэгдэлтийн үе

4.7 Томуугийн цартахал болон улирлын томуугийн хүндрэлийн үнэлгээгээр тахалт тархалтын босго үзүүлэлтээс томуу, томуу төст өвчний 10,000 хүн ам дах үзүүлэлт 1 долоо хоног давсан тохиолдол нь тахалт тархалтын үе эхэлснийг тус тус тодорхойлно.

Тав. Томуу, томуу төст өвчин, амьсгалын замын цочмог хүнд халдвартын бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэлт

5.1 Томуугийн харуулдан тандалтын нэгжүүд нь томуу, томуу төст өвчний, амьсгалын замын цочмог хүнд халдвартын тоон мэдээг 2014 оны 358 тоот тушаалын 2 дугаар хавсралтын дагуу Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Томуугийн үндэсний нэгжийн www.flu.mn цахим хуудсаар батлагдсан маягтын дагуу мэдээлнэ.

5.2 Томуу, томуу төст өвчний идэвхжил, алаг цоог дэгдэлтийн үед аймаг, дүүргийн Нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн халдварт судлагч эсвэл дүн бүртгэгч нь “Маягт 1”-ийн дагуу 7 хоног бүрийн Мягмар гарагт 12:00 цагаас өмнө Халдварт өвчин судлалын үндэсний төвийн томуугийн үндэсний нэгжид тогтмол мэдээлнэ.

5.3 Томуу, томуу төст өвчний улсын хэмжээний дэгдэлтийн үед тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төвийн халдварт судлагч эсвэл дүн бүртгэгч нь “Маягт 2”-ын дагуу өдөр бүр Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Томуугийн үндэсний нэгжид 12 цагаас өмнө тогтмол мэдээлнэ.

5.4 Томуу, томуу төст өвчний тахалт тархалтын үед Тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төвийн халдварт судлагч эсвэл дүн бүртгэгч нь “Маягт 3”-ын дагуу өдөр бүр Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Томуугийн үндэсний нэгжид 12 цагаас өмнө тогтмол мэдээлнэ.

5.5 Амьсгалын замын цочмог хүнд халдвартын шалтгаантай нас барсан тохиолдол бүрийг халдварт судлагч эсвэл дүн бүртгэгч нь “Маягт 4”-ын дагуу 48 цагийн дотор Халдварт өвчин судлалын үндэсний төвийн

5.6 Томуугийн үндэсний нэгжид тогтмол мэдээлнэ.

Зургаа. Томуу, томуу төст өвчиний дэгдэлтийн үе шатыг үнэлэх

6.1 Томуу, томуу төст өвчний тархалтын үе шатыг тодорхойлоходоо амбулаторийн үзлэгт томуу, томуу төст өвчний 10,000 хүн ам дахь өвчлөл, 16 нас хүртэлх хэвтэн эмчлүүлж буй хүүхдийн дундах амьсгалын замын цочмог хүнд халдвартын эзлэх хувийг босго үзүүлэлттэй харьцуулан тархалтын түвшинг Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс 7 хоног тутам тогтооно.

6.2 Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Ерөнхий захирлын тушаалын дагуу жил бүр томуу, томуу төст өвчний тархалтын үе шатыг үнэлэх босго үзүүлэлтийг гарган хариу арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

Хүснэгт 1. Амбулаторийн үзлэг, амьсгалын замын цочмог хүнд халдвартын босго үзүүлэлт

Үзүүлэлт Ye шат	Амбулаторийн үзлэгт томуу, томуу төст өвчний 10,000 хүн ам дахь өвчлөл	16 хүртэлх насны эмнэлэгт хэвтэгсдийн дунд амьсгалын замын цочмог хүнд халдвартын эзлэх хувь
Улирал хоорондын үе (ногоон)	<22.6	<44%
Идэвхжлийн үе (шар)	22.7-36	45%-56%
Алаг цоог дэгдэлт (улбар шар)	37-70	57%-69%
Улсын хэмжээний дэгдэлт (улаан)	71-107	70%-82%
Тахалт тархалт (ягаан)	>108	>83%

Долоо. Эрүүл мэндийн байгууллага

Эрүүл мэндийн байгууллага Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс гаргасан идэвхжлийн зэргийн үе шат бүрт тохирсон хариу арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

7.1 Эрүүл мэндийн яам

7.1.1 Томуу, томуу төст өвчний тархалтын үе шаттай уялдуулан бодлогын түвшинд шийдвэр гарган зохицуулалт хийнэ.

7.1.2 Холбогдох бусад салбар талуудын оролцоог ханган хариу арга хэмжээг уялдуулан зохицуулна.

7.1.3 Олон улсын байгууллагаас санхүүгийн болон техникийн дэмжлэг туслалцаа хүснэ.

7.1.4 Улсын хэмжээний дэгдэлтийн үед эрүүл мэндийн салбарын бэлэн байдлыг хангаж, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулна.

7.2 Халдварт өвчин судлалын үндэсний төв

7.2.1 Томуу, томуу төст өвчний тоон мэдээнд дүн шинжилгээ хийж амбулаторийн үзлэг, амьсгалын замын цочмог хүнд халдвартын босго үзүүлэлтийг гарган, олон жилийн хөдлөлзүйд суурилан хандлага, хэтийн төлвийг тодорхойлон, үе шатыг зарлаж, үндэсний хэмжээнд мэргэжил арга зүйн удирдлагаар хангана.

7.2.2 Улсын хэмжээний томуу, томуу төст өвчний 10,000 хүн ам дах өвчлөл болон хэвтэн эмчлүүлж буй 16 хүртэлх насны хүүхдийн дундах амьсгалын замын цочмог хүнд халдвартын эзлэх хувийг тооцож, босго үзүүлэлтийг жил бүрийн 8-9 дүгээр сард шинэчлэн гаргана.

7.2.3 Томуу, томуу төст өвчний тархалтын түвшинд тохирсон бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, жил бүр тодотгол хийнэ.

7.2.4 Улирлын томуугийн вакциныг төлөвлөн захиалж, түгээлтэд хяналт тавина.

7.2.5 Жил бүр вирусийн эсрэг эм, вакцин, ариутгал, халдвартүүлэлтийн бодис, эмнэлгийн хэрэгслийн тооцоог гарган, бэлэн байдлыг хангана.

7.2.6 Эрсдэлийн үнэлгээний дүн, томуу, томуу төст өвчний тархалтын үе шатанд тохирсон тохиолдлын удирдлагын тогтолцоог идэвхжүүлэн голомтод шуурхай хариу арга хэмжээний багийг томилон ажиллуулна.

7.2.7 Эрсдэлийн үнэлгээний дүн, томуу, томуу төст өвчний тархалтын үе шатанд тохицуулан сургууль, цэцэрлэгийг хаах, сурагчдын амралтыг сунгах, олон нийтийн арга хэмжээг хязгаарлах саналыг ЭМЯ, холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

7.2.8 Судалгаа, шинжилгээний ажлыг хийж, үр дүнг хэлэлцүүлэн, шийдвэр гаргагчдыг нотолгоонд суурилсан мэдээллээр хангана.

7.2.9 Эрүүл мэндийн ажилтнуудыг томуугийн тандалт, эмнэлзүй, халдвартын сэргийлэлт, хяналт, сэргийлэх арга хэмжээний талаар цогц сургалт зохион байгуулна.

7.2.10 Томуугийн харуулдан тандалтын нэгжүүдээс ирүүлсэн сорьцонд вирус судлалын шинжилгээ хийнэ.

7.2.11 Лабораторид ялгасан томуугийн вирусийн хэвшинж, дэд хэвшинж, эмийн тэсвэржилтийг болон Монгол улсад орчиж буй томуу, томуу төст өвчний бусад үүсгэгчийг дүйн тодорхойлж ДЭМБ, ЭМЯ, эрүүл мэндийн байгууллага, эмч мэргэжилтнүүдийг мэдээллээр хангана.

7.2.12 Томуугийн вирусийн зарим омгууд, ялангуяа тухайн жилийн вакцины омгийн эсрэг дархан ийлдэст бага таньцтай дүйгдсэн болон дэд хэвшинж тодорхойгүй омгуудыг ДЭМБ-ын Томуугийн лавлагaa төвүүдэд илгээнэ.

7.2.13 Томуугийн тандалтын мэдээллийг долоо хоног бүр ДЭМБ-ын FluNet, FluID сүлжээ болон үндэсний www.flu.mn вэб хуудсанд тавьж, мэдээллийг шуурхай солилцон ажиллана.

7.2.14 Вирус судлалын лабораторийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг ханган шаардлагатай урвалж, оношлуурыг захиалж, бэлэн байдлыг хангана.

7.2.15 Томуугийн үүсгэгчийн болон тандалтын орчин үеийн аргуудыг өөрийн орны нөхцөлд тохицуулан нэвтрүүлнэ.

7.2.16 Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хүн амыг үнэн зөв, бодит мэдээллээр цаг алдалгүй хангаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

7.3 Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллага

7.3.1 Аймаг, Нийслэлийн эрүүл мэндийн газар, дүүргийн Эрүүл мэндийн төв нь харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд томуу, томуу төст өвчний тандалт хийх, бэлэн байдлыг төлөвлөж, хариу арга хэмжээг зохион байгуулна.

7.3.2 Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага нь иргэдэд эмнэлгийн тусlamж үйлчилгээг шуурхай үзүүлэх, хүндрэл, эндэгдлээс урьдчилан сэргийлнэ.

7.3.3 Өрх, сумын болон сум дундын эрүүл мэндийн төв нь иргэдэд анхан шатны тусlamж үйлчилгээг шуурхай үзүүлэх, хүн амыг халдвараас урьдчилан сэргийлэх, халдварын тархалтыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

7.3.4 Ор дэлгэх нэмэлт төлөвлөгөөг жил бүр гарган, тодотгол хийнэ. Дэгдэлт, тахалт тархалтын үед амьсгалын замын цочмог хүнд халдвартай үйлчлүүлэгсдийг тусгаарлан үзэх өрөө, илрүүлэг, эрэмбэлэн ангилалт хийх хөтөч ажилтан, нэмэлтээр дэлгэх орны төлөвлөлтийг жил бүр гаргана.

7.3.5 Өвчтнийг эрэмбэлэн ангилах, жирэмсний үзлэг, хяналт, бага насын хүүхдийн товлолын дархлаажуулалт зэрэг амбулаториор үзүүлэх тусlamж үйлчилгээг өөр хэсэгт шилжүүлэх зэрэг нягтралыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

7.3.6 Эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл, ариутгал, халдвартгүйжүүлэлтийн бодисын нөөцийг бүрдүүлэх, эрчимт эмчилгээ, сэхээн амьдрзуулах тусlamж, үйлчилгээнд шаардлагатай тоног, төхөөрөмж, хүчилтөрөгчийн хангамжийн бэлэн байдлыг хангана.

7.3.7 Эрсдэлийн үнэлгээний дүнд суурилан сургууль, цэцэрлэгийг хаах зэрэг олон нийтийн арга хэмжээг хязгаарлах саналыг холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

7.3.8 Томуу, томуу төст өвчний идэвхжил, дэгдэлт, тахалт тархалтын үед эрүүл мэндийн байгууллагууд ЭМС-ын 2019 оны А/537 дугаар тушаалаар батлагдсан халдвараас сэргийлэх заавруудыг хэрэгжүүлж ажиллана.

7.3.9 Халдварын сэргийлэлт хяналтын багийн тандалт, хяналтын үйл ажиллагааг идэвхжүүлэн, эмч, эмнэлгийн ажилтнуудад халдвараас сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулж, хувийн хамгаалах хувцас, хэрэгслээр хангана.

7.3.10 Эмнэлгийн тусlamж үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн ажилтан жил бүр томуугийн эсрэг дархлаажуулалтад хамрагдсан байна.

Найм. Томуу, томуу төст өвчний тархалтын үе шатад тохирсон бэлэн байдал, хариу арга хэмжээ

8.1 Томуу, томуу төст өвчний улирал хоорондын үед бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд, засаг захиргааны нэгжүүдийн хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл

8.1.1 Томуугийн өмнөх улиралд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнд эргэмж үнэлгээ хийнэ.

8.1.2 Томуугийн хариу арга хэмжээний бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийнэ.

8.1.3 Хүний нөөцийн судалгааг гарган ажиллах эмч, мэргэжилтнийг томилон албажуулна.

8.1.4 Улирлын томуугийн вакцинд хамрагдах эрсдэлт бүлгийн хүн амын судалгааг жил бүр тодотгон, вакцины тооцоог гаргаж, захиалж, дархлаажуулна.

8.1.5 Шувуу, гахайны аж ахуй эрхэлдэг иргэд, аж ахуйн нэгжийн бүртгэл судалгааг жил бүр шинэчилнэ.

8.1.6 Томуугийн дэгдэлтийн үед лабораторийн оношлуур, хамгаалах хувцас хэрэгсэл, урвалж бодис, эм, эмнэлгийн хэрэгсэл, халдвартгүйтгэлийн бодисын тооцоог гарган нэмэлт ор, эмнэлэг дэлгэх, хүний нөөц, тоног төхөөрөмжийн бэлэн байдлын судалгааг хийж, тухайн жилийн төсөвт багтааж нөөцийг бүрдүүлнэ.

8.1.7 Эмч, мэргэжилтнийг оношилгоо, эмчилгээ, тандалт, хариу арга хэмжээ, халдвартын хяналт, сэргийлэлт, эрсдэлийн үеийн харилцаа холбооны чиглэлээр төлөвлөгөө гарган сургалт зохион байгуулж чадавхжуулна.

8.1.8 Ард иргэдэд чиглэсэн мэдээлэл сургалт сурталчилгааны төлөвлөгөө боловсруулж, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулна.

8.1.9 Сайн дурын ажилтны судалгааг гаргаж, сургаж, дадлагажуулна.

8.1.10 Эрсдэлт бүлгийн хүн амд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны материал, санамж, зөвлөмж, инфографикийг боловсруулна.

8.1.11 Эрсдэлт бүлгийн хүн амьг чийрэгжүүлэх, дархлаажуулах, нийгмийн халамжийн үйл ажиллагааг засаг захиргааны нэгжтэй хамтран зохион байгуулна.

8.1.12 Хилийн нэвтрэх цэг дээр хяналт тавихад шаардлагатай нөөцийн судалгааг гаргаж холбогдох байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран (тусгаарлах өрөө, байр, хүний нөөц, халуун хэмжигч багаж, яаралтай тусlamжийн эм, хэрэгсэл, хувийн хамгаалах хувцас хэрэгсэл) ажиллана.

8.2 Томуу, томуу төст өвчний идэвхжлийн үед бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд, засаг захиргааны нэгжүүдийн хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл

8.2.1 Томуу, томуу төст өвчний тандалтын тоон мэдээнд үндэслэн эрсдэлийн үнэлгээ хийж, хариу арга хэмжээг зохион байгуулна.

8.2.2 Сургууль, албан байгууллагуудад томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх талаар зөвлөмж хүргүүлнэ.

8.2.3 Яаралтай тусlamж, эрчимт эмчилгээний тасгийн тоног төхөөрөмж, хүний нөөцийн бэлэн байдлыг хангаж ажиллана.

8.2.4 Хүлээн авах, яаралтай тусlamжийн тасагт нэмэлтээр эрэмбэлэн ангилалт хариуцсан сувилагчийг ажиллуулна.

8.2.5 Тусгаарлах өрөөний бэлэн байдлыг хангаж, ажиллана.

8.2.6 Үйлчлүүлэгч нарт амны хаалтыг хэрэглүүлэх, гар халдвартгүйжүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.

8.2.7 Томуугийн идэвхжил, дэгдэлтийн үед эмнэлгийн тусlamж үйлчилгээний халдвартын сэргийлэлт, хяналтыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулна (урсгал зохицуулалт, эрэмбэлэн ангилал хийх).

8.2.8 Хүүхдийн боловсролын байгууллагад ирцийн тандалт хийнэ.

8.2.9 Эрсдэлт бүлгийн хүн амын үзлэгийг гэрийн эргэлтэнд шилжүүлж, хөнгөн, дунд хэлбэрээр өвчилсөн хүнийг гэрээр эмчилнэ.

8.2.10 Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэдээллээр хангаж, эрсдэлт бүлгийн хүн амд чиглэсэн үйл ажиллагаа, өрхийн эмчийн хяналтыг сайжруулна.

8.2.11 Эмч наарт томуугийн вирусийн онцлог, эмнэлзүйн менежмент, вирусийн эсрэг эм бэлдмэлийн хэрэглээний талаар (телефон, алсын зайн) сургалт зохион байгуулна.

8.2.12 Хүн амын дунд томуугаас урьдчилан сэргийлэх, мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулж, сурталчилгааны материал, инфографик, зөвлөмж, видеог бэлтгэн түгээнэ.

8.3 Томуу, томуу төст өвчний алаг цоог дэгдэлтийн үед бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд, засаг захиргааны нэгжүүдийн хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл

8.3.1 Идэвхжлийн болон алаг цоог дэгдэлтийн үеийн өвчлөл, орны мэдээг “Маят 1”, нас баралтын мэдээг “Маят 4”-ийн дагуу долоо хоног бүрийн Мягмар гарагт Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Томуугийн үндэсний нэгжид мэдээлнэ.

8.3.2 Тандалтын мэдээнд үндэслэн эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийн зэрэгт тохируулан Тохиолдлын удирдлагын тогтолцоо идэвхжиж, ажиллана.

8.3.3 Засаг захиргааны нэгж, хүүхдийн байгууллага, эмч, эмнэлгийн ажилчдыг үнэн зөв мэдээллээр хангана.

8.3.4 Үүсгэгчийн онцлогоос хамаарч, амьсгалын замын цочмог хүнд халдвартай өвчтөний ялган оношилгооны талаар зөвлөмж гаргаж, хэрэгжүүлнэ.

8.3.5 Түргэн тусламжийн үйлчилгээний машин, эмч нарын тоог нэмэгдүүлж, ОЭМТ, амбулаторийг уртасгасан цагаар ажиллуулна.

8.3.6 Эрсдэлт бүлгийн хүн амд өрхийн эмчийн үзлэг, гэрийн эргэлтийн давтамжийг нэмэгдүүлж, хөнгөн болон дунд хэлбэрээр өвчилсөн тохиолдлыг гэрээр эмчилнэ.

8.3.7 Эмнэлгийн орны зохицуулалтын төлөвлөгөөний дагуу орыг нэмэлтээр дэлгэнэ.

8.3.8 Амбулатори, хүлээн авах, яаралтай тусламжийн тасагт томуу, томуу төст өвчин болон амьсгалын замын цочмог хүнд халдвартай өвчтнийг үзэх тусгай өрөөг гарган, яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тасгийн тоног төхөөрөмж, хүний нөөцийг нэмэгдүүлнэ.

8.3.9 Томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн өвчтөний үзлэгийн өрөөг эмнэлгийн орох хаалганаас тусдаа хаалгатай, орох гарах хаалгатай ойр, олон хүний хөл хөдөлгөөнөөс зайдуу, агааржуулалт сайтай, гарын угаагууртай хэсэгт, эмнэлгээр үйлчлүүлж буй бусад үйлчлүүлэгчидтэй хавьтал болохооргүй өрөөг сонгож, амбулаторид нэмэлтээр хөтөч сувилагч ажиллуулж, эмнэлгийн гадна тал, үүдэн хэсэгт “Дуугүй хөтөч” байрлуулна.

8.3.10 Хүлээн авах, яаралтай тусламжийн тасгийг өргөжүүлэх, томуу, томуу төст өвчтэй өвчтөнд үзлэг хийж буй газар хэт бөөгнөрөл үүсгэхгүй байх, хэд хэдэн

үзлэгийн өрөөг зэрэг ажиллуулж, үзүүлэхээр ирсэн хүмүүсийг эрэмбэлэн, амны хаалт хэрэглүүлнэ.

8.3.11 Эргэлтийн цагийг хязгаарлаж, сахиурын тоог цөөлж, шаардлагагүй тохиолдолд сахиурыг солихгүй байх арга хэмжээ авна.

8.3.12 Эмнэлгийн тусlamж үйлчилгээнд халдварын сэргийлэлт, хяналтыг баримтална.

8.3.13 Томуугийн дэгдэлтийн үеийн эмнэлгийн бүтцийн загварчлалыг баримтлан ажиллана.

8.3.14 Эрүүл мэндийн сайн дурын туслагч нарыг эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаанд дайчилна.

8.3.15 Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтарч, ард иргэдэд зөвлөлгөө өгөх нээлттэй утас ажлын цагаар ажиллуулна.

8.3.16 Ард иргэд, эрсдэлт хүн ам, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, хүүхдийн байгууллагуудад мэдээлэл хийж, сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлнэ.

8.4 Томуу, томуу төст өвчний улсын хэмжээний дэгдэлтийн үед бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд, засаг захиргааны нэгжүүдийн хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл

8.4.1 Улсын хэмжээний томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үеийн өвчлөл, орны мэдээг “Маягт 2”, нас барагтын мэдээг “Маягт 4”-дагуу өдөр бүр өдрийн 12 цагаас өмнө Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Томуугийн үндэсний нэгжид мэдээлнэ.

8.4.2 Тандалтын мэдээнд үндэслэн эрсдэлийн үнэлгээ хийж, хариу арга хэмжээг зохион байгуулна.

8.4.3 Эрсдэлийн үеийн харилцаа холбооны багийг идэвхжүүлж, бүх зорилтот бүлэгт мэдээлэл хүрч байгаа эсэхэд үнэлгээ хийнэ.

8.4.4 Орон нутгийн засаг захиргааны нэгжүүдийг оролцуулан, эмзэг бүлэг, орон гэргүй иргэд өвдсөн үед эмчлэх, сувилах газрыг шийдвэрлүүлнэ.

8.4.5 Олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хамtran ажиллаж, эмзэг бүлгийнхэнд тусlamж дэмжлэг үзүүлнэ.

8.4.6 Эрсдэлийн үнэлгээний дунд тулгуурлан сургууль, цэцэрлэгийг хаах, сурагчийн амралтыг сунгах, олон нийтийн арга хэмжээг хязгаарлах саналыг орон нутгийн засаг захиргааны байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

8.4.7 Хилийн нэвтрэх цэг, холбогдох байгууллагуудтай хамtran ажиллах, мэргэжил арга зүйн зөвлөлгөөг өгөх, халуун хэмжигч багажийг хилийн нэвтрэх цэгүүдэд байрлуулах, халуунтай зорчигчдыг тусгаарлаж хяналтад байлгах, арга хэмжээг холбогдох газруудтай хамtran зохион байгуулна.

8.4.8 Товлолын дархлаажуулалтын цагийн хуваарийг нөхцөл байдалтай уялдуулдан зохицуулна.

8.4.9 Ард иргэдэд зөвлөлгөө өгөх нээлттэй утсыг 24 цагаар ажиллуулна.

8.4.10 Эмнэлэгт хэвтэх шалгуурыг нарийвчлан шаардлагагүй хэвтэлтийг багасгаж, эмнэлгээс гарсан, гэрээр эмчлэгдэж байгаа өвчтөний эмчийн хяналт, эргэлтийг эрчимжүүлнэ.

8.4.11 Өрхийн эмчийн үзлэгийг гэрийн эргэлтэнд бүрэн шилжүүлж, хөнгөн, дунд хэлбэрээр өвчилсөн тохиолдлыг гэрээр эмчилнэ.

8.4.12 Шаардлагатай үед нэмэлт эмнэлэг, орыг төлөвлөгөөний дагуу дэлгэж, хүний нөөц, тоног төхөөрөмжийн асуудлыг яаралтай шийдвэрлэнэ.

8.4.13 Хүүхдийн орны тоог нэмж бусад тасгийн үйл ажиллагааг түр зогсоож, хүүхдийн тусламж үйлчилгээнд шилжүүлэн өөр өвчтөнтэй хавьтал болохооргүй өрөө, тасгийг сонгоно.

8.4.14 Сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээний тасаг, лабораторийн хүчин чадлыг үнэлэн, нэмэлтээр нээн ажиллуулна.

8.4.15 Тэтгэвэрт гарсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн болон ΘЭМТ-өөс нэмэлт эмч, сувилагчийг дайчлан ажиллуулж, илүү цагийн хөлсийг шийдвэрлэнэ.

8.4.16 Анагаахын сургуулийн төгсөх курсын оюутнууд, резидент эмч нарыг дайчлан ажиллуулна.

8.5 Томуу, томуу төст өвчний тахалт тархалтын үед бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд, засаг захиргааны нэгжүүдийн хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл

8.5.1 Тахалт тархалтын үеийн өвчлөл, эмнэлгийн орны мэдээг “Маягт 3”, нас бааралтын мэдээг “Маягт 4”-ийн дагуу нэгтгэн өдөр бүр өдрийн 12 цагаас өмнө Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Томуугийн үндэсний нэгжид мэдээлнэ.

8.5.2 Дэгдэлт болж буй газар нутагт шуурхай хариу арга хэмжээний багийг томилон ажиллуулна.

8.5.3 Томуугийн харуулдан тандалтын нэгжүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлж, эрсдэлийн үнэлгээ хийж, эмнэлзүйн менежментийг сайжруулна.

8.5.4 Эрсдэлийн үнэлгээ, идэвхклийн зэргээр ажиллах, шаардлагатай үед Улсын онцгой комиссыг хуралдуулж, хөл хорио тогтоох асуудлыг шийдвэрлүүлнэ (үйлчилгээний байгууллагын цагийг богиносгох, хаах, г.м) хязгаарлагдмал нөөцийг зөв хуваарилна (эм, тариа, хоол хүнс).

8.5.5 Өвчтнийг эрэмбэлэн ангилж, жирэмсний үзлэг, хяналт, бага насты хүүхдийн товтолын дархлаажуулалт зэрэг амбулаториор үзүүлэх тусламж үйлчилгээг өөр хэсэгт шилжүүлж, нягтралыг бууруулна.

8.5.6 Нэмэлтээр хүлээн авах, яаралтай тусламжийн тасаг, сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээний тасаг, дүрс оношилгооны тасгийг нээж ажиллуулна.

8.5.7 Харьяа орон нутагт байрлаж байгаа хувийн оргүй эмнэлэгт зарим амбулаторийн үйлчилгээг шилжүүлнэ.

8.5.8 Нөөц эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, суралцаж байгаа резидент эмч, төгсөх дамжааны оюутнуудыг дайчлан ажиллуулж, илүү цагийг тооцон шийдвэрлүүлнэ (тэтгэвэрт гарсан эмч, сувилагч, эм зүйч, г.м).

8.5.9 Томуу, томуу төст өвчний үеийн эмнэлгийн бүтцийн загварчлалыг баримтлан ажиллана.

8.5.10 Өвчлөлийн байдалтай уялдуулан мэдээ мэдээлэл, зөвлөмжийг боловсруулан эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ард иргэдэд шуурхай түгээнэ.

8.5.11 Хувь хүн, олон нийтийн түвшинд сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг засаг захиргааны нэгж, сайн дурын ажилтануудтай хамтран зохион байгуулна.

8.5.12 Аж ахуйн нэгж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд ажлыг цахимаар хийх нөхцлийг бүрдүүлнэ.

8.5.13 Үнэн зөв, бодит мэдээлэл сургалт сурталчилгааг цахимаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай түгээнэ.

Эрүүл мэндийн сайдын 2020 оны
10 сарын 19 өдрийн 8/ тушаалын
хоёрдугаар хавсралт 482

ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧИН, АМЬСГАЛЫН
ЗАМЫН ЦОЧМОГ ХҮНД ХАЛДВАРЫГ МЭДЭЭЛЭХ МАЯГТ

**Маягт 1. Томуу, томуу төст өвчиний идэвхжлийн болон алаг цоог дэгдэлтийн
үеийн мэдээний маягт**

Он/сар/өдөр: _____ / _____ / _____ Долоо хоног _____

Эрчимт эмчилгээний тасагт байгаа хүний тоо _____

Үүнээс хүүхэд: _____ Насанд хүрэгсэд _____

Эрчимт эмчилгээний тасагт байгаа амьсгалын замын цочмог хүнд халдвартай
хүний тоо _____

Үүнээс хүүхэд: _____ Насанд хүрэгсэд _____

Нэмэлтээр зохицуулсан орны тоо /бусад тасгаас/ _____

Үүнээс хүүхэд: _____ Насанд хүрэгсэд _____ Эрчимт эмчилгээ _____

Нэмэлтээр дэлгэсэн орны тоо _____

Үүнээс хүүхэд: _____ Насанд хүрэгсэд _____ Эрчимт эмчилгээ _____

Маягт 2. Дэгдэлтийн үеийн мэдээний маягт

Он/сар/өдөр: _____ / _____ / _____

Одоо байгаа өвчтөний тоо: _____ Үүнээс хүүхэд: _____

Үүнээс: Амьсгалын замын цочмог хүнд халдварт

Нийт: _____ Хүүхэд: _____

Том хүн*: _____ Жирэмсэн эмэгтэй: _____

Эрчимт эмчилгээний тасагт байгаа хүний тоо: _____ Үүнээс хүүхэд: _____

Үүнээс: Амьсгалын замын цочмог хүнд халдварт

Нийт: _____ Хүүхэд: _____

Том хүн*: _____ Жирэмсэн эмэгтэй: _____

Яаралтай тусlamжийн тасгаар үйлчлүүлсэн хүний тоо:

Хэвтсэн: _____ Гэрээр буцсан _____

Үүнээс: Томуу томуу төст өвчин, амьсгалын замын цочмог хүнд халдварт

Хэвтсэн: _____ Гэрээр буцсан _____

Нэмэлтээр зохицуулсан орны тоо /бусад тасгаас/ _____

Үүнээс хүүхэд: _____ Насанд хүрэгсэд _____ Эрчимт эмчилгээ _____

Нэмэлтээр дэлгэсэн орны тоо _____

Үүнээс хүүхэд: _____ Насанд хүрэгсэд _____ Эрчимт эмчилгээ _____

Маягт 3. Томуу, томуу төст өвчний тахалт тархалтын үеийн мэдээний маягт

Он/сар/өдөр: _____ / _____ / _____

	Нийт	Жирэмсэн	Насны ангиллаар				
			1 хүртэл	1-4	5-19	20-64	65+
Одоо байгаа өвчтөний тоо							
Үүнээс: Амьсгалын замын цочмог хүнд халдварт							
Шинээр эмнэлэгт хэвтсэн хүний тоо							
Үүнээс: Амьсгалын замын цочмог хүнд халдварт							
Эрчимт эмчилгээний тасагт байгаа хүний тоо							
Үүнээс: Амьсгалын замын цочмог хүнд халдварт							
Яаралтай тусlamжийн тасгаар үйлчлүүлсэн хүний тоо							
Үүнээс Томуу, томуу төст өвчин, амьсгалын замын цочмог хүнд халдварт							

Нэмэлтээр зохицуулсан орны тоо /бусад тасгаас/ _____

Үүнээс хүүхэд: _____ Насанд хүрэгсэд _____ Эрчимт эмчилгээ _____

Нэмэлтээр дэлгэсэн орны тоо _____

Үүнээс хүүхэд: _____ Насанд хүрэгсэд _____ Эрчимт эмчилгээ _____

**Маягт 4. Амьсгалын замын цочмог хүнд халдвартын нас баралт мэдээлэх
маягт**

Мэдээлсэн огноо _____ / _____ / _____

Эмнэлгийн нэр _____

Мэдээлсэн хүний нэр, албан тушаал _____

Өвчтөний овог, нэр _____

Төрсөн огноо _____ / _____ / _____ Нас _____ Хүйс _____

Өвчин эхэлсэн огноо _____ / _____ / _____

Эмнэлэгт хэвтсэн огноо _____ / _____ / _____

Нас барсан огноо _____ / _____ / _____

Үндсэн онош (ICD 10) _____

Хавсарсан онош _____

Архаг суурь өвчинтэй эсэх Тийм Үгүй

Тийм бол онош _____

Вирусийн эсрэг эмчилгээ хийгдсэн эсэх Тийм Үгүй

Тийм бол хугацаа (хоног, цаг) _____

Томууний сорьц өгсөн эсэх Тийм Үгүй

Тийм бол огноо _____ / _____ / _____ хариу _____

Задлан хийсэн эсэх Тийм Үгүй

Тийм бол огноо _____ / _____ / _____ онош _____